

БАТЛАВ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



БАТЛАВ  
“ЖУГАМТЫН ГОЛ” ХХК-НЫ

ЗАХИРАЛ  Л.БАТЦЭЦЭГ



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД “ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” АЖЛЫН ГЭРЭЭ  
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202301010

2023.05.31

Хараат

Нэг талаас (цаашид “Захиалагч” гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “Жугамтын гол” ХХК-ны захирал Л.Батцэцэг (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 31 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” ажлыг ДУГАЦДСЗДТГ/202301010 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 15000.00 (Арван таван сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” ажлын 15000.000 (арван таван сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан нөхцлийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр эхлүүлж 2023 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл дууссаны дараа ажлын 7 хоногийн дотор санхүүжилт 100% хийгдэнэ.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр **нийлүүлэгчид** төлөх үүрэг хүлээнэ.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

11. Ажлыг батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

ЗДТГ-ЫН ДАРГА

..... Ш.МӨНХ-ОРГИЛ

**ХАЯГ:** Дундговь аймгийн Цагаандэлгэр  
сум Хараат 1-р баг

**Утас:** 95971666

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“ЖУГАМТЫН ГОЛ” ХХК-ЫГ

ТӨЛӨӨЛЖ

**ХАЯГ:** Улаанбаатар хот

**Харилцах банк:**

**Регистрийн дугаар:**

**Утас:** 99958898